

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ТЭРГҮҮН ДЭД ДАРГА, БРИГАДЫН
ГЕНЕРАЛ Т. АРИУНБУЯН

[Handwritten signature]

БАТЛАВ.



“ЦОМБО” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

[Handwritten signature]

Р.МӨНХЦЭЦЭГ

БАРАА, МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар 82

Улаанбаатар хот

2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

1. Нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар (цаашид “захиалагч” гэх)-ыг төлөөлж Улсын хяналт үйлчилгээний тусламжийн газрын дарга, дэд хурандаа Ч.Цогбаяр, нөгөө талаас “Цомбо” ХХК-ийн нийлүүлэгч” гэх)-ийг төлөөлж менежер Г.Дамдин нар дараах зүйлийг харилцан тогтоож 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.
2. Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, хяналт үйлчилгээ худалдан авах тухай хууль, болон бусад хууль тогтоомжийн дагуу 2020 оны Улсын хяналт үйлчилгээний зэлжит сонгуульд шинэ коронавирус /Ковид-19/-ийн цар тахлын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд сонгогчид болон сонгуулийн байранд ажиллах шаардлагад шаардлагатай бараа, материалыг бүрдүүлэх /цаашид “бараа, материал” гэх/-тэй холбоотон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
3. Энэхүү гэрээгэр 118.560 хос нэг удаагийн эмнэлгийн бээлий үнэ, чанар стандарт, хяналт үйлчилгээний хугацаа, байршлыг эцэслэн тохирох үндэслэл болно.
4. Нийлүүлэх барааны үнэ:

Барааны нэр,	Гарал үүсэл	Хэмжих нэгж	Тоо, ширхэг	Нэгж үнэ	Мөнгөн дүн
Нэг удаагийн эмнэлгийн бээлий	БНХАУ	хос	118.560	450	53.352.000
Дүн			118.560		53.352.000

5. Захиалагч нь бараа нийлүүлэлтийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.
6. Нийлүүлэгч хавсралтад заасан техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан нэг удаагийн эмнэлгийн бээлий 118.560 хосыг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улаанбаатар хот дахь Улсын нөөцийн салбарт хүргэж хүлээлгэн өгнө.
7. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний бичиг баримт” гэх). Үүнд:
 - Гэрээний ерөнхий нөхцөл /1 дүгээр хавсралт/
 - Гэрээний тусгай нөхцөл /2 дугаар хавсралт/
 - Техникийн тодорхойлолт /3 дугаар хавсралт/
 - Бараа, материал нийлүүлэлтийн болон санхүүжилтийн хуваарь /4 дүгээр хавсралт/
8. Гэрээ нь энд дурьдсан бараа, материал нийлүүлэх талаархи талуудын хоорондын эцсийн гэрээ болх ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
9. Захиалагч, нийлүүлэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
10. Нийлүүлэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан бараа, материалыг нийлүүлж, зөрчил, доголдлыг үүсгэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

11. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа, материал болон доголдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг нийлүүлэгчид төлөх үүрэг хариу хүлээнэ.

12. Захиалагчийг төлөөлөн үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцож байгаа албан хаагч болон гэрээ хэрэгжүүлэгч бүр бараа худалдан авах ажиллагаанд оролцох байгаа гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх, сонирхлын зорилго байна. Зөрчил үүссэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авна.

13. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор хариуц

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

УЛСЫН НӨӨЦ, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙН
ГАЗРЫН ДАРГА, ДЭД ХУРАНДАА

 Ц.ЦОГБАЯР

Улаанбаатар хот, СБДүүрэг,
Партизаны гудамж-6
Утас/ факс: 51-263399
Төрийн сан 100900031005
Регистрийн дугаар: 9129146

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
3-р хороо Жуулчидын гудамж-3
Утас/факс: 99116102, 99000000
ХХБанк: 499004608
Регистрийн дугаар: 2065061

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ТЭМДЭГЛЭЛ

Улаанбаатар хот

2020 оны 06 дугаар сарын 15

Онцгой байдлын ерөнхий газар, "Цомбо" ХХК-ийн хооронд 2020 оны 06 дугаар сарын 06 өдөр байгуулсан 82 дугаар гэрээний хэрэгжилтийг хоёр тал хамтран дүгнэв.
2020 оны 06 дугаар сарын 15-ны өдөр гэрээнд заасан нэг удаагийн эмнэлгийн бээлий 118.560 хосыг Улаанбаатар хот дахь Улсын нөөцийн "Объект- 03" салбарын агуулахад хангалттай хүлээлгэн өгсөн тухай.

Барааны нэр	Х/н	Гэрээний дагуу нийлүүлэх тоо	Гүйцэтгэлээр:			Олгох /төгрөг /
			Нийлүүлсэн тоо	Нэгж үнэ	Бүгд үнэ /төгрөгөөр/	
нэг удаагийн эмнэлгийн бээлий	хос	118.560	118.560	450	53.352.000	53.352.000 /тавин гурван сая гурван зуун тавин хоёр мянга/ төгрөг
Дүн		118.560	118.560		53.352.000	

2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд шинэ коронавирус /Ковид-19/-ийн цар халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд сонгогчид болон сонгуулийн байранд ажиллах албан хаагчдад шаардлагатай 118.560 хос нэг удаагийн эмнэлгийн бээлийг гэрээнд заагдсан хугацаанд техникийн тодорхойлолтын шаардлага болон гэрээний бусад нөхцлийг бүрэн хангаж хүлээлгэн өгсөн тул гэрээний биелэлтийг хангалттай тал 2 тал үзлээ.


ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

ОБЕГ-ыг төлөөлж:


Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн үйлчилгээний дарга, дэд хурандаа


Ч.Цогбаяр

УХТГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн хэлтсийн дарга, хурандаа



С.Лхагвасүрэн

УХТГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа


М.Хаш-Эрдэнэ

"ЦОМБО" ХХК-ИЙН төлөөлж:

Захирал


Р.Мөнхцэцэг

Менежер


Г.Дамдин

